



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ
БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ
ДАРГЫН ТУШААЛ

2024 оны 01 сарын 31 өдөр

Дугаар 141

Улаанбаатар хот

Г Шатрын Үндэсний шигшээ багийн
бүрэлдэхүүнийг батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3.1 дэх заалт, 8.4 дэх хэсэг, Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.7, 11 дүгээр зүйлийн 11.3.7, 11.3.9, 18 дугаар зүйлийн 18.3, 18.4 дэх хэсэг, Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2 дахь хэсэг, Монгол Улсын сайд, Олимп, нийтийн биеийн тамир, спортын Үндэсний хорооны даргын 2023 оны А/22 дугаар тушаалаар батлагдсан “Үндэсний шигшээ багийг бүрдүүлэх спортын төрлийг сонгох, санхүүжүүлэх журам”-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Шатрын Үндэсний шигшээ багийн бүрэлдэхүүний нэрсийг хавсралтаар баталсугай.

2. Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хуулийн хэрэгжилтийг ханган тус хуулийн 8 дугаар зүйлд заагдсан нээлттэй мэдээллийг байгууллагын цахим хуудсанд байршуулан мэдээллийн ил тод байдлыг ханган ажиллахыг Монголын Шатрын холбоонд үүрэг болгосугай.


3. Батлагдсан бүрэлдэхүүн, орон тооны дагуу цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг сар бүр Монголын Шатрын холбоонд шилжүүлэхийг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтсийн агентлагийн ерөнхий нягтлан бодогч (А.Өнөрцэцэг)-д зөвшөөрсүгэй.

4. Цалин, нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайлан, хувь хүний орлогын албан татварын тайланг улирал тутам хянаж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг ханган ажиллахыг Санхүү, хөрөнгө оруулалтын хэлтэс (Д.Цэрэнболд)-т, холбооны саналыг үндэслэн бүрэлдэхүүн хөдөлгөөнд тухай бүр өөрчлөлт оруулахыг Үндэсний шигшээ багийн бодлогын хэрэгжилтийн хэлтэс (Э.Билэгт)-т тус тус үүрэг болгосугай.

5. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавин ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын хэлтэс (Н.Батсүх)-т даалгасугай.


ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

О.БАТТУЛГА



1404011118

Биеийн тамир, спортын улсын хорооны
даргын 2024 оны 91 дугээр сарын 31-
ний өдрийн 14 дугаар тушаалын
хавсралт



ШАТРЫН ҮНДЭСНИЙ ШИГШЭЭ БАГИЙН 2024 ОНЫ
БҮРЭЛДЭХҮҮН

| № | Овог | Нэр | Албан тушаал |
|---|-------------|------------|---------------|
| 1 | Дүгэрээ | Төрмөнх | Дасгалжуулагч |
| 2 | Цэгмэд | Батчулуун | Тамирчин |
| 3 | Ганзориг | Амартувшин | Тамирчин |
| 4 | Сугар | Ган-Эрдэнэ | Тамирчин |
| 5 | Эрдэнэпүрэв | Болдоо | Тамирчин |
| 6 | Батхуяг | Мөнгөнтуул | Тамирчин |
| 7 | Төрмөнх | Мөнхзул | Тамирчин |
| 8 | Болдбаатар | Алтантуяа | Тамирчин |
| 9 | Энхсайхан | Хулан | Тамирчин |

---оо---